



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2025/121/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом Аудит" ХХК

Утас: 99052418 Цахим хаяг: cheegii9989@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	Error! Bookmark not defined.
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд..	13
3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	15
3.5.3 Нэмэлт төсөв:.....	16
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2. Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуй нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ШААМАР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.ӨСӨХЖАРГАЛ ТАНАА

2025.02.25 № СЭА-2025/121/НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

0

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус сургууль Боловсролын ерөнхий газраас 79,912.3 мянган төгрөгийн, ААН иргэдээс 18,557.7 мянган төгрөгийн техник тоног төхөөрөмж зэрэг нийт 98,470.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус газрын тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 92.7 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	296,057,883.60	455,120,825.33
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	155,709,921.94	311,821,278.51
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	155,709,921.94	311,821,278.51
3121	Төгрөг	155,709,921.94	311,821,278.51
31211	Төрийн сангийн харилцах	155,709,921.94	311,821,278.51
33	АВЛАГА		
35	БАРАА МАТЕРИАЛ	140,347,961.66	143,299,546.82
351	Түүхий эд материал	16,879,569.29	21,666,240.79
3511	Тусгай зориулалттай материал	16,849,569.29	21,636,240.79
3513	Эм боох материал	30,000.00	30,000.00
353	Бэлэн бүтээгдэхүүн	1,941,700.00	1,487,100.00
354	Хангамжийн материал	121,526,692.37	120,146,206.03
3542	Аж ахуйн материал	57,615,487.65	62,085,345.31
3543	Сэлбэг хэрэгсэл	6,721,100.00	6,721,100.00
3545	Барилгын засварын материал	9,859,600.00	12,223,000.00
3546	Хүнсний материал	1,598,300.00	140,700.00
3547	Бусад хангамжийн материал	45,732,204.72	38,976,060.72
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,061,898,100.96	2,145,935,931.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,061,898,100.96	2,145,935,931.34
392	Биет хөрөнгө	2,029,416,954.69	2,113,692,336.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,030,135,596.00	2,030,135,596.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-242,431,288.94	-281,039,269.88
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-13,348,958.26	-13,348,958.26
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	266,853,027.41	350,113,956.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	-134,704,348.03	-147,439,490.31
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	138,497,724.97	166,920,843.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	-82,669,768.70	-58,519,506.42
39214	Бусад үндсэн хөрөнгө	65,007,018.00	64,689,078.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-26,848,732.35	-32,914,315.66
39217	Ном	14,364,184.59	20,531,902.59
393	Биет бус хөрөнгө	32,481,146.27	32,243,594.90
39301	Программ хангамж	6,001,027.55	6,001,027.55
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,783,881.28	-4,021,432.65
39303	Бусад биет бус хөрөнгө	30,264,000.00	30,264,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,357,955,984.56	2,601,056,756.67
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
413	Өглөг		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,357,955,984.56	2,601,056,756.67

51	Засгийн газрын хувь оролцоо	2,357,955,984.56	2,601,056,756.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	756,321,843.72	756,321,843.72
512	Хуримтлагдсан үр дүн	-8,069,903.62	235,030,868.49
5121	Өмнөх үеийн үр дүн	-8,069,903.62	-8,069,903.62
5122	Тайлант үеийн үр дүн		243,100,772.11
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,609,704,044.46	1,609,704,044.46
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,357,955,984.56	2,601,056,756.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,156,662,623.20	1,849,201,512.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	49,733,823.20	198,339,384.50
120	Нийтлэг татварын бус орлого	49,733,823.20	198,339,384.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,915,428.00	13,750,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,415,428.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	13,750,300.00
120009	Бусад орлого		60,233,608.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	26,195,832.50	98,470,046.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	15,622,562.70	25,885,430.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,106,928,800.00	1,650,862,128.48
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	929,943,000.00	1,468,064,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	929,943,000.00	1,468,064,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	176,985,800.00	182,797,628.48
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	176,985,800.00	182,797,628.48
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,179,168,648.73	1,606,032,268.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,178,738,098.72	1,606,032,268.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,131,353,198.72	1,566,730,768.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	684,596,732.38	1,025,750,272.81
210101	Үндсэн цалин	506,325,295.35	662,475,961.95
210102	Нэмэгдэл	155,022,471.23	323,453,610.86
210104	Урамшуулал	23,248,965.80	39,820,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,828,311.56	124,142,349.68

210201	Тэтгэврийн даатгал	58,825,455.10	84,222,221.84
210202	Тэтгэмжийн даатгал	7,102,617.79	10,234,084.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,531,532.06	5,117,042.50
210204	Ажилгүйдлийн даатгал	1,285,550.18	4,887,763.93
210205	Эрүүл мэндийн даатгал	13,083,156.43	19,681,237.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	171,093,200.00	170,994,628.48
210301	Гэрэл, цахилгаан	11,432,325.25	12,058,428.48
210302	Түлш, халаалт	156,885,674.75	157,756,200.00
210303	Цэвэр, бохир ус	2,775,200.00	1,180,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		446,000.00
210402	Тээвэр, шатахуун		446,000.00
2105	Нормативт зардал	34,934,200.00	38,968,500.00
210502	Хоол, хүнс	34,934,200.00	38,968,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,892,600.00	124,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		124,550.00
210604	Урсгал засвар	5,892,600.00	
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,467,660.00	14,742,395.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,627,500.00	2,502,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,840,160.00	12,239,495.94
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	140,540,494.78	191,562,071.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,440,943.67	73,383,810.34
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		8,304,550.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	109,099,551.11	109,873,711.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,384,900.00	39,301,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,384,900.00	39,301,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	37,859,900.00	39,301,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,525,000.00	
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	430,550.01	
	Дотоод эх үүсвэрээр	430,550.01	
223001	Бусад хөрөнгө	430,550.01	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-22,506,025.53	243,169,244.24
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	13,240,513.21	68,472.13
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	13,240,513.21	68,472.13
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-13,240,513.21	-68,472.13
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-35,746,538.74	243,100,772.11

2.3 Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,114,844,228.00	1,664,612,428.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,915,428.00	13,750,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,915,428.00	13,750,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,915,428.00	13,750,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,415,428.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,500,000.00	13,750,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,106,928,800.00	1,650,862,128.48
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	929,943,000.00	1,468,064,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	929,943,000.00	1,468,064,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	176,985,800.00	182,797,628.48
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	176,985,800.00	182,797,628.48
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,072,781,553.94	1,473,224,711.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,072,781,553.94	1,473,224,711.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,025,287,653.94	1,434,281,811.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	673,059,143.94	1,021,408,001.92
210101	Үндсэн цалин	464,203,732.98	647,683,042.85
210102	Нэмэгдэл	185,547,524.81	337,755,684.07
210104	Урамшуулал	23,307,886.15	35,969,275.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,030,900.00	126,444,505.18
210201	Тэтгэврийн даатгал	65,980,500.00	86,329,136.76
210202	Тэтгэмжийн даатгал	7,762,500.00	10,255,059.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,209,800.00	5,127,624.70
210204	Ажилгүйдлийн даатгал	1,552,800.00	4,944,208.70
210205	Эрүүл мэндийн даатгал	15,525,300.00	19,788,475.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	171,093,200.00	170,994,628.48
210301	Гэрэл, цахилгаан	11,432,325.25	12,058,428.48
210302	Түлш, халаалт	156,885,674.75	157,756,200.00
210303	Цэвэр, бохир ус	2,775,200.00	1,180,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	74,100.00	
210402	Тээвэр, шатахуун	74,100.00	
2105	Нормативт зардал	35,953,650.00	37,510,900.00
210502	Хоол, хүнс	35,953,650.00	37,510,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,892,600.00	11,803,000.00
210604	Урсгал засвар	5,892,600.00	11,803,000.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,717,660.00	17,152,711.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,627,500.00	2,502,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,090,160.00	14,649,811.33
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,466,400.00	48,968,065.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,192,070.00	37,991,065.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,274,330.00	10,977,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,493,900.00	38,942,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,493,900.00	38,942,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	39,570,300.00	38,942,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,923,600.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	42,062,674.06	191,387,716.57
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	26,207,000.00	35,276,360.00
	Дотоод эх үүсвэрээр	26,207,000.00	35,276,360.00
223001	Бусад хөрөнгө	26,207,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		35,276,360.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-26,207,000.00	-35,276,360.00
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	15,855,674.06	156,111,356.57
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		155,709,921.94
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		311,821,278.51

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	756,321,843.72	1,609,704,044.46	-8,069,903.62	2,357,955,984.56
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Тайлант үеийн үр дүн			243,100,772.11	243,100,772.11
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	756,321,843.72	1,609,704,044.46	235,030,868.49	2,601,056,756.67

2.5 Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,820,322,350.42	1,508,501,071.91	311,821,278.51	82.9

21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,820,322,350.42	1,473,224,711.91	347,097,638.51	80.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,759,845,328.48	1,434,281,811.91	325,563,516.57	81.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,240,253,900.00	1,021,408,001.92	218,845,898.08	82.4
210101	Үндсэн цалин	798,892,300.00	647,683,042.85	151,209,257.15	81.1
210102	Нэмэгдэл	417,909,700.00	337,755,684.07	80,154,015.93	80.8
210104	Урамшуулал	23,451,900.00	35,969,275.00	-12,517,375.00	153.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	155,031,600.00	126,444,505.18	28,587,094.82	81.6
210201	Тэтгэврийн даатгал	105,421,600.00	86,329,136.76	19,092,463.24	81.9
210202	Тэтгэмжийн даатгал	12,402,500.00	10,255,059.86	2,147,440.14	82.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,201,200.00	5,127,624.70	1,073,575.30	82.7
210204	Ажилгүйдлийн даатгал	6,201,200.00	4,944,208.70	1,256,991.30	79.7
210205	Эрүүл мэндийн даатгал	24,805,100.00	19,788,475.16	5,016,624.84	79.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	170,994,628.48	170,994,628.48		100.0
210301	Гэрэл, цахилгаан	12,058,428.48	12,058,428.48		100.0
210302	Түлш, халаалт	157,756,200.00	157,756,200.00		100.0
210303	Цэвэр, бохир ус	1,180,000.00	1,180,000.00		100.0
2105	Нормативт зардал	64,699,700.00	37,510,900.00	27,188,800.00	58.0
210502	Хоол, хүнс	64,699,700.00	37,510,900.00	27,188,800.00	58.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,803,000.00	11,803,000.00		100.0
210604	Урсгал засвар	11,803,000.00	11,803,000.00		100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,125,600.00	17,152,711.33	11,972,888.67	58.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,502,900.00	2,502,900.00		100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	26,622,700.00	14,649,811.33	11,972,888.67	55.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,936,900.00	48,968,065.00	38,968,835.00	55.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,959,900.00	37,991,065.00	38,968,835.00	49.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,977,000.00	10,977,000.00		100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,367,400.00	38,942,900.00	12,424,500.00	75.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,367,400.00	38,942,900.00	12,424,500.00	75.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	45,442,200.00	38,942,900.00	6,499,300.00	85.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,925,200.00		5,925,200.00	0.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		35,276,360.00	-35,276,360.00	

	Дотоод эх үүсвэрээр		35,276,360.00	-35,276,360.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,820,322,350.42	1,664,612,428.48	155,709,921.94	91.4
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,623,774,421.94	1,468,064,500.00	155,709,921.94	90.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,468,064,500.00	1,468,064,500.00		100.0
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	155,709,921.94		155,709,921.94	0.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого				
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	182,797,628.48	182,797,628.48		100.0
132001	Орон нутгийн төсвөөс	182,797,628.48	182,797,628.48		100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	13,750,300.00	13,750,300.00		100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,750,300.00	13,750,300.00		100.0
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		155,709,921.94	155,709,921.94	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		311,821,278.51	311,821,278.51	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шаамар сумын ерөнхий боловсролын сургууль нь “*Сурагчдыг бие даан суралцах ажиллах чадвартай болгон төлөвшүүлэх, сайхан амьдрахын тулд өөрийн чадавхыг бүрэн илрүүлэн хөгжиж бүтээлчээр ажиллахад нь шаардагдах мэдлэг чадвар технологийг эзэмшүүлэхэд чиглэсэн хүртээмжтэй чанартай үр ашигтай тогтвортой үйлчилгээг үзүүлэхэд оршино*” гэсэн зорилго тавин ажиллаж байна.0

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Стандартад суурилсан боловсролын тогтолцоо сургуулийг хүний хөгжлийн төв болгон хөгжүүлэх;
- Боловсролын салбарт эрүүл аюулгүй ээлтэй орчин хүртээмжтэй үйлчилгээг бий болгох зорилгыг хэрэгжүүлэх;
- Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх

3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*

- Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 243,100.8 мянган төгрөгөөр буюу 9.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	155,709.9	311,821.3	156,111.4
Авлага			
Бараа материал	140,348.0	143,299.5	2,951.6
Үндсэн хөрөнгө	2,061,898.1	2,145,935.9	84,037.8
Нийт хөрөнгө	2,357,956.0	2,601,056.8	243,100.8
Өглөг			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,357,956.0	2,601,056.8	243,100.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,357,956.0	2,601,056.8	243,100.8

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 311,821.3 мянган төгрөг болж 156,111.4 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлтийг төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 143,299.5 мянган төгрөг болж 2,951.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 115,054.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Боловсролын ерөнхий газраас 7,852.9 мянган төгрөгийн түрээсийн ном, ААН иргэдээс 18,032.5 мянган төгрөгийн

материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, цаашид ашиглах боломжгүй 12,967.4 мянган төгрөгийн хөрөнгийг сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 129 дүгээр тогтоолын дагуу акталж данс бүртгэлээс хасаж, үйл ажиллагаанд 125,021.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас,

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 2,683,218.9 мянган төгрөг болж 117,533.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 35,276.4 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, Боловсролын ерөнхий газраас 79,912.3 мянган төгрөгийн, ААН иргэдээс 18,557.7 мянган төгрөгийн техник тоног төхөөрөмж нийт 98,470.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, цаашид ашиглах боломжгүй өртгөө нөхсөн 16,212.6 мянган төгрөгийн хөрөнгийг сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 129 дүгээр тогтоолын дагуу акталж данс бүртгэлээс хассан болон элэгдлээ нөхсөн ашиглалтын хугацаа дууссан цаашид ашиглах боломжтой 60,233.6 мянган төгрөгийн хөрөнгийг аймгийн ОНӨГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 492 дугаар албан бичгийн дагуу ашиглалтын хугацааг сунгаж данс бүртгэлд тусгасан зэрэг нь нөлөөлжээ. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 241,535.9 мянган төгрөг бөгөөд 777,447.5 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.

3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 1,187,598.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 206,558.0 мянган төгрөг, нийт 1,394,156.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин хөлс, НДШ-ийн зардлыг 35,818.5 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн зардлыг 13,545.4 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 1,218.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 36,219.2 мянган төгрөгөөр нийт 86,801.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хоолны зардлыг 3,397.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 3,000.0 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 136,167.1 мянган төгрөгөөр нийт 142,564.30 мянган төгрөгөөр бууруулж төсвийг 1,338,393.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайланд онд төсөвт 9 удаа зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 1,468,064.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 182,797.6 мянган төгрөгийн, оны эхний үлдэгдлээс 155,709.9 мянган төгрөгийн, үйл ажиллагаанаас 13,750.3 мянган төгрөгийн нийт **1,820,322.3** мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс, НДШ-ийн зардлыг 453,543.7 мянган төгрөгөөр,
- Урсгал засварын зардлыг 6,910.4 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 2,502.9 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 6,568.3 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 22,984.4 мянган төгрөгөөр,
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 8,909.9 мянган төгрөгөөр;
- Хоолны зардлыг 11,179.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж
- Тогтмол зардлыг 30,670.8 мянган төгрөгөөр бууруулсан гэх мэт

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт **1,820,322.3** мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 1,508,501.1 мянган төгрөгийг зарцуулж, 311,821.3 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,508,501.1 мянган төгрөг буюу 82.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

							<i>/мянган төгрөг/</i>	
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь	
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	2,805.2	2,805.2	-	100.0	
		2	80233-Хүүхэд хамгаалал	2,980.2	2,980.2	-	100.0	
		3	80312-Сургалт семинар	2,056.1	1,222.3	833.8	59.4	
		4	81605-Эрүүл мэндийг дэмжих	3,543.7	2,535.0	1,008.7	71.5	
		5	81801-Үдийн цай хөтөлбөр	45,442.3	38,942.9	6,499.4	85.7	
		6	81806-Дотуур байрны үйлчилгээ	230,312.0	167,178.1	63,134.0	72.6	
		7	81816-Хүүхдэд эзлтэй сургалтын орчин	17,632.1	17,613.0	19.1	99.9	
		8	81823-Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	8,210.0	2,688.5	5,521.5	32.7	
		9	81827-Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	4,323.7	2,637.5	1,686.3	61.0	
		10	81834-Боловсролын стандарт сургалтын	1,264,003.1	1,042,555.2	221,447.8	82.5	
		11	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	31,826.0	22,157.6	9,668.4	69.6	
		12	81848-Сурах бичиг	2,502.9	2,502.9	-	100.0	
		13	81875-Сургалтын нэмэлт хөтөлбөр	4,637.1	2,634.8	2,002.3	56.8	
		14	83602-ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	17,250.3	17,250.3	-	100.0	
		16	80111-Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,797.6	182,797.6	-	100.0	
		Нийт				1,820,322.3	1,508,501.1	311,821.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Үдийн цай	42,457.5	42,457.5	НТШ
2	Дотуур байрны хоол	53,519.8	53,519.8	НТШ
	Нийт дүн	95,977.3	95,977.3	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалт /Анхны батлагдсан төсвөөр тендерийн үнийн саналыг өгсөн./ - ыг 2 удаа зарлаж, гүйцэтгэгчээр шалгарсан “Сэлэнгэ буман буудай” ХХК-тай 2024 оны 10 дугаар сарын 15-нд гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын ерөнхий боловсролын сургуулийн /цаашид Шаамар сумын ерөнхий боловсролын сургууль гэх/ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шаамар сумын ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,179,149.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 11,791.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Шаамар сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус сургууль нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь

шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй болно.

4.5 ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

4.5.1 Завсрын аудитын талаар

“Пийк Ом аудит” ХХК нь 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 913 дүгээр албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг тус байгууллагад хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг санхүүгийн тайланд зөв тусгахтай холбоотой өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	387.4	1	387.4	100.0
Нийт дүн	1	387.4	1	387.4	100.0

4.6 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах 35,276.4 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Худалдан авсан 35,276.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд бараа материалын зардлаар бүртгэж тусгасан;

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илэрсэнгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.